



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 11447

Есөнбулаг

Г Хөрөнгө гаргах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир Уулын аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд соёлын биет бус өв язгуур урлагийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн олон нийтэд хүргэх, танилцуулах "Tune" эвент зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



ଶ୍ରୀମଦ୍ଭଗବତ

۱۰۷

دیوان حافظه

卷之三